



хөгжлийн төв". "Сумын төв доторх 2.5 км хатуу хучилттай зам" тавих ажлуудын төслийг Улсын Их Хуралд өргөн бариад байна.



ТАНАЙ СУМЫГ ЗОРИН ИРЭХ ИРГЭДЭД ЯМАР БОЛОМЖ, НӨХЦӨЛ ОЛГОХ ВЭ?

Манай суманд зорин ирэх иргэдэд дараах бизнесийн орчинг бүрдүүлж ажиллана. Үүнд:

1. Газар тариалангийн хувьд 22600 га эргэлтийн талбайтай учир тариа будаа тариалах, үүнийгээ дагаад гурил тэжээлийн үйлдвэр байгуулах, хүнсний ногоо тариалж, бусад сумдруу нийлүүлэх, хүнс нарийн ногоо нөөцлөх агуулах байгуулах бүрэн боломжтой
2. Мал аж ахуйн салбарын бизнес эрхлэх иргэд, аж ахуй нэгжүүдэд эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлнэ. Бэлчээр, ургамлын шим тэжээл өндөр тул мал тарга тэвээрэг авч иргэд, аж ахуй нэгжүүдэд эрсдэлгүй бизнесийн үйл ажиллагаа явуулах таатай нөхцөл бүрдэх юм.
3. Ойн аж ахуй болон мод, модон эдлэлээр үйл ажиллагаа явуулах, мод үржүүлгийн цогц үйлчилгээ явуулахад сумын зүгээс бүх талаар дэмжиж ажиллахад бэлэн байна.
4. 300 жилийн түүхтэй Амарбаясгалант хийд болон Баруунбүрэн сумын нутаг дэвсгэрт байрлах байгалийн үзэсгэлэнт газруудад түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх бүрэн боломжтой юм.



Баруунбүрэн сум



НЭЭЛТТЭЙ СЭЛЭНГЭ



"СЭЛЭНГИЙН ИРЭЭДҮЙ- ТОГВОРТОЙ НОГООН ХӨГЖИЛ"

СУМ ОРОН НУТГИЙН ОНЦЛОГ

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сум нь хуучнаар Түшээт хан аймаг Ахай засгийн хошууны бүрэлдэхүүнд байж байгаад 1924 онд Баруунбүрэн хан уулын хошуу нэртэй байгуулагджээ. Сумын төвийг 1926 онд Улаан хошууны дуганын газар байрлуулж суурьшаар одоогийн оршин буй Цагаан овооны шинэ төвд 1980 онд шилжин ирсэн байна. 1954 оны 10 сард нутгийн иргэдийн санаачилгаар Өрнөлт нэгдэл байгуулан газар тариалан мал аж ахуй эрхэлж байжээ. 1976 оны 11-р сард Баруунбүрэн сумын "Өрнөлт" нэгдэлд Цагаантолгойн САА-н Бургалтайн тасаг нэгдэж 1976 оны 12-р сарын 26-нд БНМАУ-ын СнЗ-ийн тогтоолоор Бургалтайн САА байгуулагджээ.

Баруунбүрэн сум нь одоогоор засаг захиргааны 3 баг, 889 өрхийн 3107 хүн амтай.

Төсвийн 5 байгууллага, сум дундын ойн анги 1, банк 2, ШТС 2, ойн мэргэжлийн байгууллага 1, аж ахуйн нэгж 38, худалдаа үйлчилгээний 8 цэг, газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг 22 аж ахуйн нэгжтэй.



88251413



<http://baruunburen.se.gov.mn/>

Газарзүйн байрлалын хувьд Сэлэнгэ аймгийн баруун урд захад байрлалтай, Улаанбаатар хотоос 310 км, аймгийн төвөөс 220 км, Эрдэнэт хотоос 65 км, Дархан хотоос 110 км зайд байрладаг. Хүн амын төвлөрөл бүхий томоохон хот суурин газруудтай ойр, зам харилцаа сайтай.

Нийт 281454 га нутаг дэвсгэртэй, урдуураа Сэлэнгэ мөрөн, Орхон голын үржил шим бүхий сав газар хар хүрэн хөрстэй, уулын ар модтой бэсрэг уулс бүхий ойт хээр хосолсон буюу газар тариалан мал аж ахуй эрхлэхэд нэн тохиромжтой газар юм.

Сумын иргэд, аж ахуйнэгж голлон газар тариалан, мал аж ахуйн салбарт бизнес эрхэлдэг бөгөөд эдгээр чиглэлд бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллаж байна. Сумын хэмжээнд 26 аж ахуй нэгж, 60 гаруй иргэн газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж, газар тариалангийн зориулалтаар ашиглагддаг нийт 22600 га эргэлтийн талбайг 100 хувь ашиглаж байна.

2022 онд базмал ааруулаараа “Сэлэнгийн брэнд” бүтээгдэхүүн болсон бөгөөд малчин эмэгтэйчүүд нь уг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж Улаанбаатар, Дархан, Сэлэнгэ, Орхон аймгийн зах зээлд нийлүүлдэг онцлогтой. Мөн байгалийн дагалдах баялаг болох эмийн ургамлаараа 4 нэр төрлийн цай үйлдвэрлэж байна.

Арвай тарьж арвайн гурил үйлдвэрлэдэг жижиг оврын цехтэй. Манай сум нь ойн сан бүхий 96000 га талбай ойтой, самар жимс элбэг бөгөөд ойн дагалдах баялгаар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хаягдал мод модон материалыг ашиглан үйлдвэрлэл үйлчилгээ явуулах боломжтой.



СУМЫН ХӨГЖИХ БОЛОМЖ:

Манай сум нь Дархан, Эрдэнэт хотуудын дунд оршдог бөгөөд сумын нутаг дээгүүр Дархан Эрдэнэтийг холбосон улсын чанартай 46 км хатуу хучилттай засмал зам дайран өнгөрдөг. Мөн “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх станц” ТӨХК-ийн эрчим хүчний шугамд холбогдсон, байнгын цахилгаан хангамжтай. Үүрэн холбооны Мобиком, Жи-Мобайл, Юнитель, Скайтилийн сүлжээнд

холбогдсон. Төр төсвийн байгууллагууд нь төвийн нэгдсэн халаалтад холбогдсон. Эдгээр нь иргэд оршин суугчдын хувьд алслагдсан бус эсрэгээрээ хотууд, аймгийн төв, бусад сумдын хөгжилтэй хөл нийлүүлэн алхах маш таатай нөхцөл юм.

Сумын нутаг дэвсгэр Бүрэнхаан уулын хормойд Ивэн голын зүүн бие Шар дов хэмээх дэвсэг дээр 1727 онд Түшээт хан Гомбодоржийн 3 дугаар хөвгүүн халхын Анхдугаар Богд Жавзандамба Өндөр Гэгээн Занабазарт зориулж Манжийн найралт төв хааны зарлигаар 4 үе шаттайгаар 120 орчим жил барьж байгуулсан шашин, түүх, соёл урлагийн хосгүй үнэт өв дурсгал, уран барилгын хосгүй нандин бүхнийг шингээсэн Амарбаясгалант хийдтэй. Хийдийг түшиглэсэн 5 жуулчин баазтай бөгөөд гадаад, дотоодын аялагчдыг хүлээн авах хүчин чадалтай. Ийм өвөрмөц онцлог давуу талаа ашигласан хөгжлийн зохистой төлөвлөгөө хэрэгжүүлж чадвал ирээдүйд аялал жуулчлалын өлгий нутаг болох бүрэн боломжтой юм.



ХОТ ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭЖ БҮЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖИЛ, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ

- Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор санаачлан хэрэгжүүлж буй “Шинэ хөдөө” төслийн хүрээнд “Өвөл - Зуны хүлэмж”-ийг цогцоор нь барьж байгуулсан.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Ивэн 1 дүгээр багт “Албан бус боловсролын төв”-ийг шинээр барьж байгуулсан.
- Нутгийн удирдлагын ордонг шинээр барьж байгуулан хүлээж аваад байна.
- Замын сангийн хөрөнгө оруулалтаар сумын төвийн гэрэлтүүлгийг засварлаж, огт гэрэлтүүлэггүй хороолол, гудамд шинээр гэрэлтүүлэг тавьсан.
- Аймгийн хөрөнгө оруулалтаар “Бууцан бордоо боловсруулах цех” байгууллаа.
- ОНХС болон сумын хөрөнгө оруулалтаар нийтдээ 960.4 сая төгрөгний хөрөнгө оруулалт санхүүжилт хийгдсэн байна.
- Хүнс Нийгмийн Хамгааллын яамны санхүүжилтээр баригдах “Хүүхэд залуучуудын